

**“Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн 2020 оны 04 сарын 24-ны өдрийн ээлжит
хурлын протокол:**

2020 оны 04 сарын 24 өдөр

№01

Улаанбаатар хот

Хаана: Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх тосгон, “Бэрх Уул” ХК-ийн захиргааны байр

Эхэлсэн цаг: 09:00 цагт

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Баярцэнгэл, хурлын нарийн бичиг Н.Содончимэг, тооллогын комиссын дарга Э.Уянга нар, итгэмжлэлээр 4 хувьцаа эзэмшигч, нийтдээ 4 хувьцаа эзэмшигч оролцов.

Тооллогын комиссын дарга Э.Уянга “Бэрх Уул” ХК-ийн 2020 оны 04 сарын 24-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулъя. Нийт 19’062’080 ширхэг хувьцаанаас нийтдээ 99.66% буюу 18’997’615.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өөрийн биеэр оролцож хурлын ирц бүрдэж байгааг мэгдэгдэж байна.

Хурлын ирц: 99.66 хувь

Хурлын дарга компанийн гүйцэтгэх захирал А.Даваажав та бүхэнд танилцуулга хийнэ.

Хурлын дарга А.Даваажав: Хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн мэнд хүргье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

- ✓ Хурлын ирцийг бүртгэх
- ✓ Хурлын ирцийг мэдээлэх
- ✓ Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
- ✓ Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
- ✓ Хурлын завсарлага
- ✓ Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлыг хаах

Хурлаар хэлэлцэх асуудлууд

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2020 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2020 оны зардлын төсвийг батлах

6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
7. Бэрхийн уурхайн “Уулын цех”-ийн хэсгийг түшиглэн Далд уурхайн музей байгуулахтай холбоотой гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
8. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай ТУЗ-ын бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлах
9. “Бэрх Уул” ХК-ийн эсрэг “Эм Эн Юу Би кредит” ХХК-ийн шүүхийн нэхэмжлэлтэй хэргийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
10. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
11. Хөрөнгө шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
12. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах
13. Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлын дарга А.Даваажав: 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

“Бэрх Уул” ХК нь 2019 онд нүүрс олборлон борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан.

1. Чандганы нүүрсний уурхайн хэсэг:

Чандганы нүүрсний уурхайн хэсэг нь 2019 оны 10-р сараас 2020 оны эхний хагас жилийн халаалтын улирлын хөрс хуулалтын ажлыг, 2019 оны 8-р сарын 26-наас эхлэн 9-р сарын 28-ны хооронд нийт 184,000 м3 хөрс хуулалтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Хөрс хуулалтын ажилд компанийн өөрийн техникүүд болох KOMATSU-D155A бульдозер, DOOSAN эксковатор, ZL50C-автоашигч зэрэг техникүүдийн ашиглалтын хугацаа дууссан, явах эд анги болон бусад эд анги муудсан зэргээс шалгаалан хөрс хуулалтын ажлыг хийж чадахгүйд хүрсний улмаас хувь хүмүүс болон компаниудаас техник түрээслэн, мөн түр хугацаанд үнэ төлбөргүйгээр зарим техникүүдийг авч ашигласан.

Тус түрээсийн техникүүдийг 2 ээлжээр ажилуулсан үүнд:

- “Цэнхэр өрлөг” ХХК-с 2 ширхэг Doosan500 эксковаторыг өдрийн 20 цаг, тус бүр 28 хоног буюу 560 мото цаг ажиллахаар түрээслэв. / 98,0 сая төгрөг /
- “Пүүл ресорос” ХХК-с автосамосвалл 3 ширхэг / 22,1 сая төгрөг /
- Хувь хүмүүсээс автосамосвалл 7 ширхэг / 83,0 сая төгрөг /

- Запрукша 30 хоногийн хугацаатай ширхэг / 3,0 сая төгрөг /

Мөн холбогдох компаниудаас түр хугацаагаанд дараах техникүүдийг төлбөргүй ашигласан

- Бульдозер 1 ширхэг
- ZL50C-автоачигч 1 ширхэг

Хөрс хуулалтын үеэр нүүрсний нөөц, судлын унал, давхаргын бүтэц, усны түвшинг тодорхойлох зорилгоор “Экспресстрейд” ХХК-иар 300 тууш метр буюу 7 ширхэг цооног өрөмдөхөд 22,0 сая төгрөг зарцуулсан.

Техник тоног төхөөрөмж

Компанийн техникүүдэд:

- Бульдозерт турбин солисон, бусад нэн шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн
- Эксковаторт гинж, радиатор, сум, шанага, цилиндр зэргийг бүрэн солиж бусад засвар үйлчилгээг хийсэн
- ZL50C-автоачигчид моторын бүрэн ээлж, дугуй бусад засвар үйлчилгээг хийсэн

Сэлбэг засвар үйлчилгээний зардалд 40,0 гаруй сая төгрөг зарцуулсан.

Ажилчдын байр

Компанийн ажилчдын байранд их засвар болон тавилга эд хогшил шинэчлэхэд 60,0 гаруй сая төгрөг зарцуулсан. Үүнд:

- Бүх өрөөнүүдийн шалыг ховхолж элс, хайрга, дайрга хийж, цементлэн плита болгосон
- Бүх өрөөнүүдийг дотор засал хийсэн
- Гал тогооны өрөөнд иж бүрэн тохижуулж, цэвэр усны тосгуур суурилуулж дотроосоо усаа авдаг, халуун хүйтэн устай болсон
- Дээврийн засвар хийсэн
- Интернэтэд холбосон

Бусад

- Поссын шинэ программ нэвтрүүлсэн ба жижиглэнгийн бүх гүйлгээ НӨАТ-шивэх үйлчилгээг иж бүрэн нэвтрүүлсэн.
- Тэмдэг тэмдэглэгээнүүдийг шинэчлэн хийсэн
- Гадна орчныг камержуулсан
- Галын сараа хийсэн
- Клонкын шатахууны ёмкосыг будаж үүдэнд нь цемент цутгасан
- Чацарганы суулгац 350 ширхэг, алмны модны суулгац 11 ширхэгийг мөн улиасны суулгац зэрэг суулгацуудыг тус тус суулгасан

Чандганы уурхайн ажилчдыг хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцсаар

хангаж, хор саармагжуулах сүү, аарц, чацарганы шүүсийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэж байна.

“Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгаа”-г байгууллагын онцлогт тохируулан боловсруулж мөрдөж, ажилчдад ХХАА-ны дүрэм журмыг тогтмол өгч, гарын үсгээр баталгаажуулан ажилладаг.

Борлуулалт

Чандганы хэсгийн нүүрсний борлуулалт болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ашиг алдагдлыг сүүлийн 3 жилээр тооцож үзвэл:

Хүснэгт-1 Хураангуй тайлан

№	Төрөл	Хэмжих нэгж	2017	2018	2019
1	Нүүрсний борлуулалт тн	тн	54,669.0	51,740.5	58,157.09
2	Нүүрсний борлуулалт /төг/	сая.төг	1,148.74	1,149.02	1,355.18
3	ББӨ	сая.төг	971.15	932.0	889,51
4	Нийт үйл ажиллагааны ашиг	сая.төг	177.59	217.02	465.67

2.Тусгай зөвшөөрлийн тухай:

Тус компани нь MV-04590, MV-00166, MV-10965 гэсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрлүүдийн төлбөр хугацаандаа төлөгдөн явж байна.

3.Боловсон хүчний тухай:

2019 онд тус компани нь Захиргааны хэсэгт-10 ажилчин, Чандганы нүүрсний уурхайн хэсэгт-11 ажилчин, Харуулын албаны хэсэгт-13 ажилчин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр, нийт 34 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс эмэгтэй-12, эрэгтэй-22.

МШӨ-ний групптэй-2, энгийн групптэй-1, ахмад настан-5 эдгээр ажиллагсадыг эрүүл мэндэд харшлахгүй хөнгөн ажлаар ханган ажиллаж байна.

Тус компани нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаанд мөрдлөг болгож, 2 жил тутам шинэжилдэг. Ажил олгогчийн зүгээс ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулж, шинээр орсон ажилтантай 3 сар хүртэл туршилтын гэрээ байгуулан ажиллуулдаг. Мөн ажиллагсдын цалинг сар бүрийн сүүлийн 7 хоногт олгож, нийгмийн даатгалын дэвтэрт үнэн зөв бичилт хийн баталгаажуулж байна.

4.Санхүү:

Компанийн 2019 оны орлого үр дүнгийн тайлан, баланс

2019 оны байдлаар 58,157.09 тн нүүрс олборлон борлуулж 1,355,18 сая төгрөг, нүүрс тээврийн орлого нь 4,8 сая төгрөг, түрээсийн орлого 4,1 сая төгрөг, жоншны агуулагатай шороо борлуулсаны орлого 283,2 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө борлуулсаны

олз 5,03 сая төгрөг, харилцах дансанд бодогдсон хүүгийн орлого 0,61 сая тус тус олсон байна. Нүүрс борлуулахад гарсан ББӨ 889,51 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 576,02 сая төгрөг, санхүүгийн зардал буюу зээлийн хүүгийн зардал 1,948.46 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний алдагдал (968.4) сая төгрөг болж, нийт энэ онд (2,763.35) төгрөгийн алдагдалтай ажилласан.

Хүснэгт-1 Орлого үр дүнгийн тайлан

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2018 он	2019 он
Борлуулалт	сая. төг	1,149.02	1,355.18
ББӨ	сая. төг	932.00	889.51
Нийт ашиг	сая. төг	217.02	465.67
Бусад орлого	сая. төг	95.30	297.90
Ерөнхий удирдлагын зардал	сая. төг	543.83	576.02
Санхүүгийн зардал	сая. төг	2,123.34	1,948.46
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	(2,354.85)	(1,760.91)
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая. төг	(20.61)	(33.98)
Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	сая. төг	(2,143.60)	(968.40)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая. төг	(4,519.06)	(2,763.29)
Орлогын татварын зардал	сая. төг	0.04	0.06
Татварын дараах ашиг (алдагдал)	сая. төг	(4,519.10)	(2,763.35)

Хүснэгт-2 Хураангуй баланс

№	Хураангуй баланс	2018.12.31	2019.12.31
1	ХӨРӨНГӨ:		
2	Эргэлтийн хөрөнгө	140.12	254.25
3	Эргэлтийн бус хөрөнгө	14,006.95	13,981.04
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,147.07	14,235.29
5	ӨР ТӨЛБӨР:		
6	Богино хугацаат өр төлбөр	14,720.58	16,839.12
7	Урт хугацаат өр төлбөр	29,615.30	30,348.79
8	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:	44,335.88	47,187.91
9	ЭЗДИЙН ӨМЧ		
10	Хувийн өмч	1,906.21	1,906.21
11	Дахин үнэлгээний нэмэгдэл	1990.69	1,990.69
12	Хуримтлагдсан ашиг	-34,085.70	-36,849.51
13	ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН	(30,188.81)	(32,952.62)
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,147.07	14,235.29

2019 оны татвар, нийгмийн даатгалын шимтгэл:

Компани нь санхүүгийн тайлан баланс болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж, аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан цаг хугацаанд нь төлж барагдуулж байгаа. 2019 онд татварт 260,5 сая төгрөг төлж 83,4 сая төгрөгийн өртэй, мөн нийгмийн даатгалын шимтгэлд 143,9 сая төгрөг төлж шимтгэлийн өргүй гарсан.

Хүснэгт-3 Татварын тайлан

№	Татварын төрөл	2019 оны эхний үлд	Үүссэн	Төлсөн	2019 оны 12.31 үлд
1	Агаарын бохирдол		29,078,545	29,078,545	-
2	АМНАТ		33,879,434	33,879,434	-
3	ААНОАТ				-
4	НӨАТ	51,758,580	142,177,567	112,331,008	81,605,139
5	ХАОАТ	38,376,431	32,492,463	70,868,894	0
6	Суутган 10	1,484,667	3,959,259	3,648,148	1,795,778
7	АТӨЯХАТ		655,000	655,000	-
8	АТӨЯХАБТ		43,300	43,300	
9	ҮХХАТ		6,473,398	6,473,398	-
10	Газрын төлбөр / Бэрх /		165,594	165,594	-
11	Газрын төлбөр / Дэлгэрхаан /		917,440	917,440	-
12	Газрын төлбөр / Чандган /		2,329,100	2,329,100	-
13	Галт зэвсгийн татвар		120,000	120,000	-
14	НД-н шимтгэл	35,470,337	108,458,362	143,928,699	-
Нийт дүн		127,090,015	360,749,462	404,438,561	83,400,917
Татвар НДШ-н хураангуй					
№	Татварын төрөл	Эхний үлд	Үүссэн	Төлсөн	Эцсийн үлд
1	Татвар	91,619,678	252,291,100	260,509,862	83,400,917
2	НД-н шимтгэл	35,470,337	108,458,362	143,928,699	0
Нийт дүн		127,090,015	360,749,462	404,438,561	83,400,917

2019 оны үйл ажиллагааг дүгнэвэл

Тус тайлант хугацаанд компани нь хэдий алдагдалтай ажилсан боловч Чандганы хэсэг нь хөрс хуулалт, нүүрс борлуулалт, техникийн засвар үйлчилгээ, ажилчдын байрны их засварын ажил, цахилгааны шийдний шинэчлэл, уурын зуухны шинэчлэл, хайгууль өрөмдлөг, зэрэг олон ажилуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Бэрхийн оффисийн бүх ажилчдад нормын хувцас, мөн эмэгтэй ажилчдыг иж бүрэн оффис хувцасаас хангасан. Ажилчдын амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд зориулж фитнесийн иж бүрэн тоног төхөөрөмж, ширээний теннис, зэргийг суурилуулсан.

Оффисын гадна талбайд алимны мод, уурхайн гадна талбайд 2 настай Чацарганы суулгац, алимны мод суулгасан.

Дэлгэрхааны орд газарт цахилгааны техникийн нөхцөл, гүний уурхайн ус соруулалтын ажлыг хийсэн.

Мөн сум орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээний дагуу Мөрөн сумын хогын цэгийг түрэх, зорилтод бүлгийн хүмүүст нүүрс олгох болон зорилтот бүлгийн өрхөд шинэ гэр хандивласан.

Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос баталсан нүүрсний зохицуулалттай үнээр буюу 1 тонн нүүрсийг 23'000 төгрөгөөр борлуулж байгаа нь уурхайн үйл ажиллагаа болон компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Уурхайн уул техникийн нөхцөл хүндэрсэн, олборлолтын өртөг жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь цаашид техникийн шинэчлэлт хийх боломжгүй болгож, улмаар хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байна.

Үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой санал:

- Хөрс хуулалтын үеэр 2 ээлжээр явах нь зөв боловч шөнийн ээлжийн хоолны цагийг оновчтой тогтоох. Шөнийн ээлжийн ажлын бүтээл 03 цагаас хойш нийтлэг буурч байсан ба ялангуяа шөнийн 02-06 цагт. Тиймээс хоёр ээлжээр ажиллах тохиолдолд цагийн хуваарийг өглөөний 06 цагаас шөнийн 03 цаг байхаар ээлжийн хуваарийг тохируулах.
- Талбайн гэрэлтүүлгийн асуудлыг оновчтой шийдвэрлэх нь шөнийн ээлжийн ажлын бүтээлд нөлөөлөхөөр байна.
- Шөнийн гэрэлтүүлэг сайтай үед туслах ажилтан буюу дохиочин шаардлагагүй болох боломжтой.
- Талбай, зам, маршрутыг камержуулах, Wireless GPS-ээр хянах, хяналтын тогтолцоог бүрдүүлэх
- Сумдууд, төрийн байгууллагууд болон зарим нэг төрийн байгууллагууд нүүрс худалдан авах тендер зарладаг болсон. Үүнтэй холбоотойгоор тендерт оролцож борлуулалтын тоо хэмжээг нэмэх боломжтой.
- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах нүүрс тээвэр болон хөрс хуулалтанд ашиглах 20 кубын ачааны машинтай болох.
- Агуулах, сэлбэг, түлш зарцуулалт, шатах тослох материалын зарцуулалтын тайлангийн анхан шатны мэдээллийн бааз үүсгэх, тайланг хөтлөх,

автоматжуулах, улмаар ажилтны хөдөлмөрийн бүтээмжийг бодитой үнэлэх үнэлгээний систем бий болгох.

- 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээн олборлох нүүрсийг 65'000 тоннд хүргэж борлуулах.
- Хэт бага үнээр борлуулж буй нүүрсний үнэнд зохих өөрчлөлтийг оруулах.
- Усан доороос нүүрс олборлох, нүүрс олборлолтын өртгийг бууруулах тал дээр онцгой анхаарах
- Чандганы уурхайн хөрс нь бороо орсны дараа техник явах боломжгүй болдог тул техникүүдийн гэрээнд борооноос үүдэлтэй сул зогсолттой холбоотой заалтыг нарийвчилан оруулж өгөх.
- Урт хугацаанд ашиглагдах замын тэмдэг тэмдэглэгээ, замын нөхцөлийг сайжруулах.
- Отволын гэрэлтүүлэгийг сайжруулах, урт хугацаанд тогтвортой овоолго үүсэх нөхцөлийг бүрдүүлэх
- Усан доорх боломжит нүүрсийг авч, дотоод овоолго үүсгэх уулын ажлын төлөвлөгөөг урт хугацаагаар төлөвлөж боловсруулах, улмаар хөрс хуулалтын нэгжийн өртгийг бууруулах.

БЭРХ УУЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД

НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Р.Бадрах-Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 10 жилийн сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. ЗХУ-д Киев БТДС-ийг, Улаанбаатар хот Удирдлагын академийг тус тус төгссөн. 2001-2010 онд Хүрээ Дэл ХХК-д Захирлаар ажиллаж байсан ба одоо тус компанид Зөвлөхөөр ажиллаж байна. Монголын усан спортын холбоонд 1994-оноос одоог хүртэл Удирдах зөвлөлд ажиллаж байна.

Б.Наранзаяа-Гурван Тамир сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. БНХАУ-ын Анхуйгын Их сургуульд бакалавр, Монгол улс Удирдлагын академид Мастерийн зэргээр тус тус суралцаж төгссөн. 2007-2008 онд “Чалко Хонгхонг” ХХК-д Захирлын туслах, 2008-2013 онд “Болд ФоАрДа” ХХК-д Орчуулагч, 2013 оноос одоог хүртэл “Чингисийн Хар Алт” ХХК-ийн захирлаар ажиллаж байна.

А.Даваажав-МУИС-ЭЗС -г банк санхүүч мэргэжлээр 2007 онд, МУИС-ХЗДС -г 2018 онд эрх зүйч мэргэжлээр төгссөн. Анод банкинд алт, валют арилжааны дилер, ТЕГ-т мэргэжилтэн, Туушин Инвест БДК-д арилжаа хариуцсан ахлах дилер, Чингисийн Хар Алт ХХК-д санхүү эрхэлсэн захирал, “Ирвэс Интертрейд” ХХК-д гүйцэтгэх захирал, 2019 оны 8 сарын 01-с “Бэрх Уул” ХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Б.Аригуун -ӨЗБТС программист мэргэжлээр 2003 онд, МУИС-ЭЗС эдийн засаг, хүн ам зүйч мэргэжлээр 2007 онд төгссөн. Юнител ХХК-д маркетингийн мэргэжилтэн, төслийн менежер, Алтанбулаг чөлөөт бүсийн ажлын албаны дарга, Ирвэс-Интертрейд ХХК гүйцэтгэх захирал, “Эм Жи Эл Акуа” ХХК гүйцэтгэх захирал, “Спүүн медиа” ХХК үүсгэн байгуулагчаар ажиллаж байна.

Б.Баярцэнгэл -ӨМӨЗО Хөх хотын багшийн их сургуулийг 2010 онд төгссөн. Вольф группийн менежер, “Хүрээ Дэл” ХХК-д менежер, “Вайльд Вольф” ХХК-д гүйцэтгэх захирал, “Ачир” ХХК-д ерөнхий менежер, 2019 оноос “Төгс Элит Дизайн” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Ө.Алдарбаяр -БХИС-ын харьяа ХЦДС -д эрх зүйч мэргэжлээр 1999 онд төгссөн. “Хүрээ Дэл” ХХК, “Говь Эрдэнэс Энержи” ХХК-д гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

Л.Тэмүүжин-Улаанбаатар хотын 81-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. ШУТИС-д Геодезийн инженерийн мэргэжлээр төгссөн. “Хүрээ Дэл Майнинг” ХХК ахлах маркшейдр, “Төгс Элит Дизайн” ХХК гүйцэтгэх захиралаар тус тус ажиллаж байна.

Ё.Амарбат-Нийслэлийн 28-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. МУИС-ын Эдийн засгийн сургууль, Гадаад хэл, соёлын сургуулийг тус тус төгссөн.

Сангийн яам: Мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Төрийн банк: Санхүүгийн газрын захирал, Албаны менежер

МИАТ ТӨХК, Багануурын ДЦС ТӨХК болон Монсам ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байна.

Д.Энхболд-Нийслэлийн 67-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. ШУТИС, КТМС-ийн бизнесийн удирдлагын бакалавраар, Удирдлагын академид Стратегийн удирдлага болон бизнесийн удирдлагын магистраар тус тус мэргэжил эзэмшсэн. Одоо Hewlett Pacard Enterprise монгол дахь төлөөлөгчийн бизнес хөгжлийн менежерээр ажиллаж байна.

Хурлын дарга А.Даваажав: Хэлэлцэх асуудал 2-6 хүртэл ямар нэг асуух асуулт байхгүй бол шууд баталцгаая.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлав.

Хэлэлцэх асуудал 3: 2020 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

Хэлэлцэх асуудал 4: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгов.

Хэлэлцэх асуудал 5: ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2020 оны зардлын төсвийг батлав.

Хэлэлцэх асуудал 6: Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлав.

Хурлын дарга А.Даваажав: “Бэрх Уул” ХК-ын өмнө нь ашиглаж байсан “Уулын цехийн” хэсгийг түшиглэн Далд Уурхайн музей байгуулахтай холбоотой ашиглагдахгүй байгаа зарим хөрөнгийг түүхэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлж өгөөч гэсэн хүсэлт тавьсан ба үүнтэй холбоотой товч танилцуулга хийх нь зүйтэй байх.

Хэлэлцэх асуудал 7. Бэрхийн уурхайн “Уулын цех”-ийн хэсгийг түшиглэн Далд уурхайн музей байгуулахтай холбоотой гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах.

“Бэрх Уул” ХК-ийн өмнө нь ашиглаж байсан “Уулын цех”-ийн хэсгийг түшиглэн Далд Уурхайн музей байгуулахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын гишүүн, Л.Оюун-Эрдэнэ гишүүний 2019.04.19-ны өдрийн 4078 тоот албан тоотын хариу болгож компанид одоо ашиглагдахгүй байгаа 0227158 тоот газрын гэрчилгээтэй, 703 м.кв талбайтай “Уулын цехийн барилга”, 0227158 тоот газрын гэрчилгээтэй, 1293 м.кв талбай бүхий бутлах, ялгах, баяжуулах цех болон бэлэн бүтээгдэхүүний барилгуудыг “Монголын далд уурхайн сургалт судалгааны төв, гүний уурхайн музей” түүхэн аялал жуулчлалын цогцолбор байгуулахтай холбоотой дээрх хөрөнгүүдийг үнэ төлбөргүй шилжүүлж өгөөч гэсэн хүсэлт тавьсан.

Хувьцаа эзэмшигч: Дээрх хөрөнгүүд нь манай дараа дараагийн төсөлүүдэд хэрэг болохгүй юу?

Хурлын дарга А.Даваажав: Ерөнхийдөө ашиглагдахгүй гэж хэлж болно. Бодитоор ашиглаж болох ганц өндөр таазтай барилга болох хуучин Механик цехийн барилгыг бол сэргээгээд ашиглаж болохоор байгаа. Уг барилга нь бидэнд хуучин зориулалтаар нь эсвэл авто засварын төвийн зориулалтаар ашиглахад бүрэн боломжтой барилга юм.

Хувьцаа эзэмшигч: Нийт хичнээн хэмжээний талбайг хамарсан газрыг өгөхөөр байна? Бидэнд дараа дараагийн төслийг хэрэгжүүлэхэд ямар нэг бүтээн байгуулалт хийхтэй холбоотой газрын асуудал гарах уу?

Хурлын дарга А.Даваажав: Хүлээлгэж өгөх барилга байгууламжууд нь ойролцоогоор 5-7 га талбайг хамарч байгаа. Гэхдээ газрын гэрчилгээтэй барилга 2 ширхэг байгаа ба газрын гэрчилгээ нь барилгын сууриараа байдаг.

Хувьцаа эзэмшигч: 5-7 га орчим талбай хамарсан газрыг хүлээлгэж өгөх юм байна гэж ойлголоо. Тэгвэл энэ хэмжээний газрыг өөр газар дүйцүүлэн бусад төсөлдөө ашиглахаар авах хэрэгтэй. Учир нь газрын асуудал өөрөө хугацаа их шаарддаг, хүнд суртал ихтэй учир дараа дараагийн төсөлд ашиглах газрыг өөр газар авахаар зохицуулах хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч: Уулын цех нь Жоншны нөөц байгаа юу? Нөөц нь бүрэн дууссан юм уу? Газар өгнө гэхээр өөрсдийн жоншны нөөцтэй газараа өгчих гэж байгаа юм биш биз?

Хурлын дарга А.Даваажав: Уулын цехийг ерөнхийдөө 8 горизонтоор 400 метр хүртэл гүнд ашигласан гэдэг ба нөөцийг ерөнхийдөө бүрэн авсан гэдэг.

Хувьцаа эзэмшигч: “Уулын цех”-ын хэсгийн далд уурхайг анх 1950-иад оны үеэс ашиглаж байсан /Доошоо 8 горизонт байгаа, зурган дээр нурсан гэж тэмдэглэсэн байна/.

Хадгаламжид тавьсан зурагнаас харж байхад 2 горизонт, 100 м явсан байна. Тус уурхайн нэвтрэлт 1991-1992 онуудад зогсож, 1995 онд хадгаламжид тавьсан байна. Анх батлагдсан нөөц нь 5.0 орчим сая тонн ба 50 жилийн хугацаанд ихдээ гэхэд 3.0 орчим сая тонныг олборлосон байх боломжтой байна. Энэ талаар мэдээлэл байна уу? Үлдэгдэл 2.0 сая тонн нөөц байгаа юм биш үү?

Хурлын дарга А.Даваажав: Уулын цехийн геологийн нөөц, олборлосон хэмжээ, үлдэгдэл нөөцийг судалж байсангүй. Энэ талаар нарийн судалж ТУЗ болон Хувьцаа эзэмшигчид тусгайлан судалгааг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигч: Нэр дурдсан хөрөнгүүдийг Далд Уурхайн музейн зориулалтаар ашиглуулахыг ерөнхийдөө зөвшөөрч байна. Харин газар доорх жонш болон эрдэс нь компанийн гэдгийг ойлгоорой. Өөрөөр хэлбэл бид усан хадгаламжинд тавьсан байгаа.

Хувьцаа эзэмшигч: Ер нь 600-1000 метрийн гүнтэй 20 ширхэг цооног буюу 12'000-20'000 тууш метр өрөмдөж үзвэл дээр биш үү?

Хурлын дарга А.Даваажав: Болохгүй ч юм байхгүй л дээ. 2.4-4.0 орчим сая ам.долларын өрмийн зардал гарах байх.

Хувьцаа эзэмшигч: Одоогийн нөхцөл байдалд эдийн засгийн хувьд 400 метрээс доош гүнд олборлолт явуулах нь ашиггүй. Магадгүй 20 жил, 30 жилийн дараа эдийн засгийн хувьд ашигтай байж болох юм.

Хувьцаа эзэмшигч: Бид ашиглахгүй байгаа барилга байгууламжийг л Далд Уурхайн музейн зориулалтаар ашиглуулахаар өгч байгаа болохоос хадгаламжинд тавьсан жоншийг өгөөгүй. Тэгэхээр хуулийн хувьд бид эдийн засгийн хувьд ашигтай гэж үзсэн хэдийд ч хадгаламжинд тавьсан жоншийг лицензжүүлэх давуу эрх нь бидэнд байгаа гэж ойлгож байна зөв үү?

Хурлын дарга А.Даваажав: Энэ талаар судалж үзье. Логикын хувьд боломжтой. Судалгаагаар хэрэв эдийн засгийн хувьд ашигтай байхаар нөөц тогтоогдвол Музей гүний уурхай 2 маш сайн хослох болно. Гэхдээ ойрын 10 жилдээ л эдийн засгийн хувьд ашиггүй гэсэн урьдчилсан тооцоо хийгдсэн ба хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа өндөр гэсэн тооцоо хийгдсэн.

Хувьцаа эзэмшигч: Дэлхийн зах зээл дээр жоншны баяжмалын үнэ 650 ам.долларыг давсан тохиолдолд 5.0 сая ам.долларыг зөвхөн гүний өрөмдлөг тавихад шийдэж өгч болно. Тиймээс судалгааг орхигдуулж болохгүй. Далд Уурхайн музейтэй холбоотой бүтээн байгуулалт, хөрөнгө шилжүүлэх ажлыг ерөнхийдөө дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч: Далд Уурхайн Музейн зориулалтаар Монгол Улсын Засгийн газар, Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яам, холбогдох нэгжид шилжүүлэх хөрөнгийг зөвхөн Музейн зориулалтаар ашиглахаар хүлээлгэж өгөх, шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд өөр зориулалтаар шилжүүлэх, ашиглуулахгүй байх зохицуулалтыг холбогдох гэрээнд тусгаж ажиллах нь зөв байх. Шилжүүлж өгөх хөрөнгийг албан ёсоор, ёслол төгөлдөр хүлээлгэж өгөөрэй.

Хурлын дарга А.Даваажав: Өөр асуух асуулт байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудал-7 тай холбоотой гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах уу?

Хэлэлцэх асуудал 7. Бэрхийн уурхайн “Уулын цех”-ийн хэсгийг түшиглэн Далд уурхайн музей байгуулахтай холбоотой гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлав.

Хэлэлцэх асуудал 8. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай ТУЗ-ын бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлав.

Хурлын дарга А.Даваажав: **Хэлэлцэх асуудал-9:** Өнөөдөр “Бэрх Уул” ХК-ын хувьд “Эм Эн Юу Би кредит” ХХК-тай холбоотой шүүхийн нэхэмжлэл нь тулгамдсан асуудал болоод байгаа тул та бүхэн анхааралтай танилцаж холбогдох шийдвэрүүдийг гаргаж өгнө үү. Мөн уг хэлэлцэх асуудлыг хурлын нарийн бичиг Н.Содончимэг хурлын тэмдэглэлд тусгахаас гадна, тусад нь тогтоол-9 ын хүрээнд дахь хэсэгчилсэн тэмдэглэлийг үйлдэх нь зөв байх. Учир нь уг тэмдэглэл дараа дараагийн шүүхийн шатанд нотлох баримт болно.

Хэлэлцэх асуудал 9. “Бэрх Уул” ХК-ийн эсрэг “Эм Эн Юу Би кредит” ХХК-ийн шүүхийн нэхэмжлэлтэй хэргийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай:

Хурлын дарга А.Даваажав : “Бэрх уул” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 оны 03 сарын 09-ний өдөр 14 дүгээр тогтоолыг баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлснийг танилцуулж байна.

Хэнтий аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас шийдвэр гүйцэтгэгчийн 2019 оны 09 сарын 11-ний өдрийн зарлан дуудах мэдэгдэлийг компанид ирүүлсэн бөгөөд уг асуудлаар миний бие очиж уулзахад “Бэрх Уул” ХХК-иас 3,137,667,000 төгрөгийг гаргуулж “Эм Эн Юу Би Кредит” ХХК-д олгохоор шүүхийн шийдвэр гарч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлсэн байдаг.

Гэтэл уг шүүхийн шийдвэрийн талаар тус компанийн хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд мэдээлэлгүй байснаас гадна 2019 оны 10 сарын 18-ны өдөр “Бэрх Уул” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдаж, 07 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн хурал”-ын тогтоолоор компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд өөрчлөгдөн томилогдож, компанийн өмнөх ТУЗ болон удирдлагаас компанийн баримт материалыг хүлээлцэн авч, 2019 оны 10 сарын 22-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороонд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалыг хүргүүлсэн.

Хувьцаа эзэмшигч: Шинээр томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд удирдлага өмнөх ТУЗ-өөс компанитай холбогдож гарсан өмнөх цаг үеийн материалыг хүлээн авсан гэж ойлгож болох уу?

Хурлын дарга А.Даваажав: Тэгж ойлгож болно. Улмаар Санхүүгийн зохицуулах хороонд 2019 оны 10 сарын 30-ны өдөр “Компанийн удирдлагын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, баримт бичгүүдийг хүлээлцэн авсантай холбогдуулан “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн нэрс, холбогдох мэдээлэл гаргуулах” тухай хүсэлт хүргүүлсний дагуу тус хорооноос 2019 оны 11 сарын 08-ны өдөр 9/3897, 9/3248 дугаар албан бичгээр өмнөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн компанитай холбоотой гаргаж байсан шийдвэр, баримт материалуудыг манай компанид ирүүлсэн болно.

Баримт материалуудыг шалгаж байх үеийн явц, баримт материалууд болон 2019 оны 10 сарын 30-ны өдрийн Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 1350 дугаартай лавлагааг та бүхэнд танилцуулж байна. Дээрх баримтуудыг шалгаж үзэхэд хэд хэдэн нөхцөл байдал тодорхой болсон.

“Бэрх Уул” ХК-ийн тухайн үеийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2014 оны 06 сарын 12-ны өдрийн 17 дугаартай “Зээл авах тухай” тогтоолыг гаргаж компанийн үйл ажиллагаанд зориулан “Эм Эн Юу Би Кредит” ХХК-иас 1 жилийн хугацаатай, сарын 1,5%-ийн хүүтэй, 100'000 ам.долларын зээлийг 500,000 ам.доллар хүртэлх зээл авах зээлийн шугамын зөвшөөрөл олгож, уг зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Мэндсайханд даалгаж шийдвэрлэсэн байдаг.

Хувьцаа эзэмшигч: Зээлийн гэрээний дүн нь 100'000 ам.доллар юм уу , эсвэл 500'000 ам.доллар юм уу?

Хурлын дарга А.Даваажав: Үндсэн зээлийн гэрээний дүн нь 100'000 ам.доллар, 500'000 ам.доллар хүртэл зээлийн шугам ашиглах гэрээний заалттай зээлийн гэрээ юм.

Хувьцаа эзэмшигч: Энэхүү зээлийн шугамаас хэдийг нь ашигласан байдаг вэ?

Хурлын дарга А.Даваажав: Уг зээлийн шугамаас 300'000 ам.долларыг ашигласан байдаг ба “Эм Эн Юу Би Кредит” ХХК-иас “Бэрх Уул” ХК-ын дансанд ам.доллараар 180'000 ам.доллар, төгрөгөөр 219'088'800.0 төгрөг буюу нийтдээ 300'000 ам.доллар орж ирсэн байдаг.

Хувьцаа эзэмшигч: Тэгээд яагаад 300'000 ам.долларын зээл нь 3'137'667'000.0 төгрөг буюу ойролцоогоор 1.15 сая ам.доллар болж нэхэмжлэгддэг билээ?

Хурлын дарга А.Даваажав: Дотоод аудитын хорооны дүгнэлт болон хараат бус хөндлөнгийн аудитын шинжээчийн дүгнэлтээр Б.Мэндсайхан нь үндсэн зээлийг 500'000 ам.доллар болгож өөр компанийн орж ирсэн гүйлгээг нэмж бүртгэсэн, зориудаар зээлийн нэмэлт гэрээ гэгчийг хожим хууль зөрчиж, зохих зөвшөөрөлгүйгээр байгуулсан байдаг ба түүндээ алданги тооцохыг зөвшөөрсөн. Түүнчлэн шүүхэд 500'000 ам.доллар авсан гэж тайлбар өгснөөс шүүхээс 3,137,667,000 төгрөгийн шийдвэр гаргасан байдаг. Мөн анхан

шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах хуулийн хугацааг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон ТУЗ-ын даргадаа мэдэгдэлгүйгээр санаатайгаар дарж өнгөрөөсөн байдаг.

2014 оны компанийн санхүүгийн тайлан, баланс, үйл ажиллагааны тайлан мэдээ, зээлийн зарцуулалтыг шалгаж үзэхээр компанид тухайн үед ийм хэмжээний зээлийг авах шаардлага байхгүй байсан ба энэ байдлын талаар “Эс Эм Аудит” ХХК-ийн зүгээс 2020 оны 03 сарын 26-ны өдрийн албан гэрээний дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомжийг үндэслэн “Эм Эн Юу Би кредит” ХХК-тай холбоотой Зээл, зээлийн хүүтэй холбоотой хараат бус шинжээчийн дүгнэлтийг ирүүлснийг та бүхэнд танилцуулж байна.

Хувьцаа эзэмшигч: Яагаад энэ тухай өмнө нь мэдэгдээгүй юм бэ? Хувьцаа эзэмшигчийн хувьд үүнийг анх удаа сонсож байна. Уг асуудалтай холбоотой одоо ямар ажиллагаа хийгдэж байгаа вэ?

Хурлын дарга А.Даваажав: Тухайн үеийн гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан энэ талаар ТУЗ болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөлгүй ирснээс шүүхийн шатанд холбогдох баримтуудаа гаргаж маргаагүй, зээлийг авсан гэж хүлээн зөвшөөрөөд шийдвэрийг гаргуулаад явсан байдаг. Одоо Иргэний шүүхээр маргаан бүхий 2014 оны Зээлийн гэрээ, 2015 оны Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл болохыг тогтоолгох, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах зэрэг бүхий л боломжийг хуулийн ферм болон өмгөөлөгч нар судлан ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч: Зээлийн гэрээ компанийн сонирхлын зөлчилтэй хэлцэл эсэх талаар ямар ажиллагаа хийсэн бэ?

Хурлын дарга А.Даваажав: Санхүүгийн Зохицуулах Хорооноос өмнөх ТУЗ-ын гаргасан шийдвэрүүдтэй холбоотой баримт материалыг гэрээт хуулийн ферм болон өмгөөлөгч нарт гарган өгч судлуулсан. Баримтаар “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.Батбаатар өөрийн эхнэрийн компаниас зээл авахуулсан байдаг ба “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан Б.Батхуяг нь “Эм Эн Юу Би Кредит” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан байна. Нэг ёсондоо Б.Батбаатар, О.Солонго болон Б.Батхуяг нар нь нэг талаас зээл олгогч болсон бол нөгөө талаас зээл авагч байдлаар оролцсоноо компанид мэдэгдээгүй.

Эдгээр нөхцөл байдлыг шалгуулахаар “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналын дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хороонд “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014.06.12-ны өдрийн 17 дугаар тогтоол хуульд нийцэж гарсан эсэх, “Бэрх Уул” ХК болон “Эм Эн Юу Би Кредит” ХХК нарын хооронд 2014.05.25-ны өдөр байгуулагдсан 02/01 дугаар “Зээлийн гэрээ”-ний талаар дүгнэлт гаргахыг даалгасан болно.

“Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хорооны 03 дугаар дүгнэлтээр “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014.06.12-ны өдрийн 17 дугаар тогтоол нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4, 84.4.4, 85 дугаар зүйлийн 85.1, 91 дүгээр зүйлийн 91.1, 91.1.1, 91.1.2, 91.1.4, 91.2, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгийг тус тус зөрчсөн, “Бэрх Уул” ХК болон “Эм Эн Юу Би Кредит” ХХК нарын хооронд 2014.05.25-ны өдөр байгуулагдсан 02/01 дугаар “Зээлийн гэрээ” нь компанийн сонирхлын зөрчилтэй хэлцэл болохыг тус тус дүгнэсэн байна.

Ийнхүү компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014.06.12-ны өдрийн 17 дугаар тогтоолыг 2020 оны 03 сарын 09-ний өдрийн 14 дүгээр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор хүчингүй болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлүүлэхээр ирүүлсэн.

Хувьцаа эзэмшигч: Баримт материалуудтай танилцаж нөхцөл байдлыг ойлголоо. Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмыг зөрчиж гарсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014.06.12-ны өдрийн 17 дугаар тогтоолыг бүрэн эрхийн хүрээнд хүчингүй болгож, уг зээлийн гэрээтэй холбоотой хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч ажиллуулах саналтай байна. Учир нь уг тогтоол, Зээлийн гэрээтэй холбоотойгоор “Бэрх Уул” ХК нь аваагүй зээлийн өр төлбөр, түүний хүү, алдангийн ихээхэн хэмжээний өр төлбөрт орж, үндэслэлгүйгээр төлөх ёстой болж, цаашилбал компанийн гол үйл ажиллагаа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар зогсонги байдалтай болж байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хурлын дарга А.Даваажав: Ойлголоо. “Эм Эн Юу Би Кредит” ХХК-тай холбоотой өөр асуулт байхгүй бол саналаа хураая.


Тооллогын комиссын дарга “Эм Эн Юу Би Кредит” ХХК-тай холбоотой санал хураалтын дүнг танилцуулав.

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан 14 дүгээр шийдвэрийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 06 сарын 12-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болгохыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. Уг тогтоолоос үүссэн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх, Компанийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1, 93 дугаар зүйлийн 93.1, 93.2, 93.3 дугаар зүйлд тус тус заасны дагуу арга хэмжээ авч, компанийг хохиролгүй болгох, шүүхэд нэхэмжлэл гаргах зэргийг хариуцан ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх захирал А.Даваажавд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.

Хурал:11:15 өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “Бэрх Уул” ХК-ийн эсрэг “Эм Эн Юу Би кредит” ХХК-ийн шүүхийн нэхэмжлэлтэй хэргийн талаар Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан 14 дүгээр шийдвэрийг зөвшөөрч баталсугай.
2. “Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 06 сарын 12-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай;
3. Уг тогтоолоос үүссэн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх, Компанийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1, 93 дугаар зүйлийн 93.1, 93.2, 93.3 дугаар зүйлд тус тус заасны дагуу арга хэмжээ авч, компанийг хохиролгүй болгох, шүүхэд нэхэмжлэл гаргах зэргийг хариуцан ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх захирал А.Даваажавд даалгасугай

Хурлын протокол хянасан хурлын дарга: ...../А.Даваажав/

Хурлын протокол хөтөлсөн: ...../Н.Содончимэг/

Хэлэлцэх асуудал 10: Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлав.

Хэлэлцэх асуудал 11: Хөрөнгө шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлав.

Хэлэлцэх асуудал 12: Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлав.

Хэлэлцэх асуудал 13: Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлав.

Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Э.Уянга хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулав.

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. 2020 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
4. Компанийн шинэ ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдээс Р.Бадрах 16.7%, Б.Наранзаяа 16.7%, А.Даваажав 16.7%, Б.Аригуун 16.7%, Б.Баярцэнгэл 16.7%, Ө.Алдарбаяр 16.7%, тус тус саналтайгаар ердийн гишүүнээр сонгогдлоо.
Хараат бус гишүүдэд Л.Тэмүүжин 33.3%, Ё.Амарбат 33.3%, Д.Энхболд 33.3% саналтайгаар тус тус хараат бус гишүүдээр сонгогдлоо.
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2020 оны зардлын төсвийг батлав тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
7. Бэрхийн уурхайн “Уулын цех”-ийн хэсгийг түшиглэн Далд уурхайн музей байгуулахтай холбоотой гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
8. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай ТУЗ-ын бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.

9. “Бэрх Уул” ХК-ийн эсрэг “Эм Эн Юу Би кредит” ХХК-ийн шүүхийн нэхэмжлэлтэй хэргийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
10. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
11. Хөрөнгө шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
12. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
13. Зээл, өр төлбөрийн талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна

Хурал:13:30 өндөрлөв

Хурлын протокол хянасан

Хурлын дарга:

...../А.Даваажав/

Хурлын протокол хөтөлсөн

...../Н.Содончимэг/

